

## ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД БА ОРОН НУТГИЙН ИРГЭД

### БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах
- Өөрийн үйл ажиллагаа явуулж буй орон нутагт шинэ, сайжруулсан эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх.

### ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Хүн амын шилжин суурьшилт нэмэгдэхтэй холбогдон халдварт өвчний гаралт нэмэгдэх
- Замын хөдөлгөөн ихэсч авто замын аюулгүй ажиллагааны аюул нэмэгдэх
- Барилгын ажлын явцад тоосжилт нэмэгдэх
- Хүн амын тоо нэмэгдсэнээс үүдэн хувь хүний аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх.

### БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

ОЛОН НИЙТЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР  
ДООРХИ АЖЛУУДЫГ ХИЙГЭЭД БАЙНА. ҮҮНД:

- ХДХВ/ДОХ, Б хэлбэрийн халдварт шар болон цусаар дамжих бусад халдварт өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх хөтөлбөрт зориулан 243 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн
- Ханбогд сумын төвд анхны шүдний эмнэлгийг байгуулсан бөгөөд тус эмнэлгээр Ханбогд сумын хүн амын 80 гаруй хувь нь үйлчлүүлээд байна





- Ханбогд сумын төвийн эмнэлгийн саяхан хийгдсэн шинэчлэлд санхүүгийн туслалцаа үзүүлсэн
- Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвд хөрөнгө оруулалт хийсэн
- Эмнэлгийн ажилтнуудыг тус бүс нутагт тогтвортой ажиллахад туслалцаа үзүүлэх зорилгоор Бүсийн Эрүүлийг хамгаалах байгууллагын мэргэжилтнүүдийг хадгалан авч үлдээх зорилгоор эмчийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн (2012 онд бид 1-1.5 сая төгрөгийг 25 эмчид олгосон бөгөөд тус хөтөлбөр нь одоо 7 дахь жилдээ хэрэгжин, бид туслалцаа дэмжлэгийг үргэлжлүүлэн үзүүлсээр байна).

#### АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

- Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчдэд хүний эрхийн сургалт явуулж, зааварчилгаа өгөх замаар осол гэмтлийн эрсдлийг бууруулахын тулд аюулгүй байдлын арга хэмжээг нэмэгдүүлэх
- Харуул хамгаалалтын ажилтан болон цагдаагийн бие бүрэлдэхүүнд хүний эрхийн сургалт явуулах
- Аюулгүй байдалтай холбоотой зөрчлүүд дээр гадны оролцогч талуудыг (жишээ нь цагдаа) татан оролцуулах
- Олон нийтийн зүгээс гарах гомдол, маргааныг шийдэх журмын дагуу тулгараад буй асуудлуудыг хянаж нягтлах.

#### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА:

- Оюу Толгойн тээврийн хэрэгслийн бүх жолооч, операторуудад аюулгүй ажиллагааны сургалт явуулах
- Оюу Толгойн тээврийн хэрэгслүүдийг өдөр болон шөнийн цагаар аюулгүй жолоодох стандартыг бий болгох
- Замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг зохион байгуулах
- Замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны онцлог байдлыг хэрэгжүүлэх – жишээ нь тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, ан амьтдын зам гатлах газрууд болон гүүрэн гарцыг байгуулах гэх мэт.

#### ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ:

- Цаашид төлөвлөж буй томоохон хэмжээний барилгын ажлын талаар орон нутгийн ард иргэдэд цаг тухайд нь, үнэн зөв мэдээлэл хүргэж байх
- Малыг авто замын осолд өртөх эрсдлээс сэргийлэхийн тулд орон нутгийн малчидтай холбоотой ажиллах.



Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөлийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г [www.ot.mn](http://www.ot.mn) цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.